

МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ, ШУУРХАЙ УДИРДЛАГЫН АЛБАНЫ  
ХЭМЖЭЭНД ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
ЧИГЛЭЛЭЭР 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2022.12.05

Улаанбаатар хот

Нэг. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх /код 900/”, “Албан тушаалд томилох болзол, шаардлага, шалгуур /код 901/”, “Алба хаагчийг шилжүүлэн ажиллуулах /код 908/”, “Албан тушаал дэвшүүлэх /код-909/” журмын хэрэгжилтийн талаар:

Албаны хэмжээнд хүний нөөцийн бодлого үйл ажиллагааг хэрэгжүүлэх, алба хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, шатлан дэвшүүлэх зарчим, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх /код 900/”, “Албан тушаалд томилох болзол, шаардлага, шалгуур /код 901/”, “Алба хаагчийг шилжүүлэн ажиллуулах /код 908/”, “Албан тушаал дэвшүүлэх /код-909/” журмуудыг тус тус баримтлан албаны харьяа нэгжээс хүний нөөцийн томилгооны талаарх ирүүлсэн саналын дагуу 2022 онд томилгооны 405, цол, шагналын 340, нийт 745 санал, материалыг хүлээн авч шийдвэрлэсэн. Үүнд:

Дэвшүүлэн томилуулахаар 64, /үүнээс: тасгийн даргаар 14, ахлах зохицуулагчаар 3, ахлах байцаагч, программ хангамжийн ахлах инженер, тусгай шуудангийн ахлах мэргэжилтэн, жижүүрийн техникийн ахлах мэргэжилтнээр тус бүр 1, жижүүрийн ахлах мөрдөгчөөр 25, мэдээлэл, судалгааны ахлах мэргэжилтнээр 8, холбоо, мэдээллийн ахлах инженерээр 10/, офицер бүрэлдэхүүнд оруулахаар 39, шинээр томилуулах 19, шилжүүлэн томилуулахаар 86, албанаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх 22, цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгохоор албанаас чөлөөлөгдөх 49, хүүхэд асрах чөлөө олгуулах 12, хүүхэд асрах чөлөөг цуцлуулж, урьд эрхэлж байсан албан тушаалд томилуулах 7, цагдаагийн алба хаах хугацааг сунгуулах 2 алба хаагчийн материалыг тус тус бүрдүүлж, Хүний нөөцийн хэлтэст хүргүүлж, 23 алба хаагчийн саналыг татгалзаж, баримт бичгийг буцаасан. Албаны харьяа нэгжүүдээс ирүүлсэн баримт бичгийн дагуу холбогдох алба, газар, хэлтсээс 84 алба хаагчид санал авч, шилжүүлэх 66 алба хаагчийн баримт бичигт дэмжсэн, 12 алба хаагчид татгалзсан саналыг тус тус хариу хүргүүлсэн.

Буцалтгүй тусламж, цалинтай чөлөө олгох 7, ажилд орох 6, хөдөлмөрийн гэрээ цуцлах 5, тодорхойлолт олгуулах 5, нийт 23 алба хаагчийн өргөдөл, хүсэлтийг хүлээн авч, 5 алба хаагчид тодорхойлолтыг гаргаж холбогдох байгууллагад хүргүүлсэн, албаны даргын тушаалаар 7 алба хаагчид буцалтгүй тусламж, цалинтай чөлөөг олгож, 5 алба хаагчтай хөдөлмөрийн гэрээ цуцалж, 3 алба хаагч, 3 ажилтныг томилж, “Алба хаах гэрээ”, “Хөдөлмөрийн гэрээ” байгуулсан. /дутагдлаар халагдсан 5, нас барсан 1 нь томилгооны саналын тоонд ороогүй/,

2022 оны жилийн эцсийн байдлаар тус албаны харьяа нэгжийн хэмжээнд батлагдсан орон тоогоор нийт 1022 алба хаагч ажиллахаас 943 алба хаагч үүрэг гүйцэтгэж, 79 орон тоо дутуу байна. Мөн онд 81 алба хаагч өөр алба, нэгжид шилжин томилогдож, 89 алба хаагч чөлөөлөгдсөн, тус орон тоонуудад 155 алба хаагчийг нөхөн томилсон нь хүний нөөцийн нөхөн хангалт 91.1 хувьтай.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар баталсан тушаалаар баталсан “Албан тушаалд томилох болзол, шаардлага, шалгуур /код-901/ журам”-ын “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад алба хаах гэрээний үлгэрчилсэн загвар”-ын дагуу албаны даргаас нийт алба хаагч бүртэй шинэчилсэн гэрээ байгуулж, офицер алба хаагчдын гэрээг ХНХ-т хүргүүлсэн.

Алба хаах гэрээ”-ний 4.2.1-д заасан “...Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад офицер, ахлагчийн албан тушаалд анх томилогдсон алба хаагч нь тухайн албан тушаалд 2 /хоёр/-оос доошгүй жил тогтвор суурьшилтай ажиллах”, 4.2.2-д заасан “...өөр албан тушаалд томилогдсон алба хаагч нь тухайн албан тушаал бүрт 1 /нэг/-ээс доошгүй жил тогтвор суурьшилтай ажиллах” тус тус үүргийн дагуу алба хаагчийн эрхзүйн байдлыг дээрдүүлж, дэвшүүлэн томилуулах, эрүүл мэнд, ар гэрийн гачигдал зэрэг хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад шилжилт хөдөлгөөнийг багасгаж, алба хаагчдыг мэргэшүүлэх, үр

бүтээлтэй ажиллуулах шаардлагад нийцүүлж, шилжүүлэн томилуулах 44 алба хаагчийн саналыг татгалзаж, холбогдох нэгжид хариу өгсөн.

Тус албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэр дэх Автотавиулангийн барилгыг цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон нь Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2018 оны 02-07-383/712 дугаар актаар тогтоогдож, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 474 дүгээр тогтоолоор дээрх барилгыг акталж, данснаас хасах шийдвэр гарсан тул Захиргааны удирдлагын хэлтсийн диспетчер-харуул орон тоонд ажиллаж байсан 3 алба хаагчийн хөдөлмөрийн гэрээг цуцалж, Хөдөлмөрийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1-д заасны дагуу тэтгэмж олгох тушаалыг батлуулж, холбогдох баримт бичгийг бүрдүүлж, СААА-нд хүргүүлсэн.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Байгууллагын даргын тушаал гаргах” код-136 журамд заасан үндэслэл, тавигдах шаардлагын дагуу албаны даргын хүний нөөцийн “Б” тушаалын төслийг боловсруулж, 286 алба хаагчдад холбогдох 104 тушаалыг батлуулсан.

Мөн Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны оны 06 дугаар сарын 16-ны өдрийн А/184 дүгээр тушаалыг тус тус үндэслэн Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд зохион байгуулагдсан мэргэжлийн зэргийн шалгалтад тэнцсэн 20 алба хаагчид мэргэжлийн зэргийн, 3 алба хаагчид нууц хамгаалах ажилтан, нууцын бичээчийн, үйлчилгээний 2 алба хаагчид ур чадварын нэмэгдлийг тус тус олгож байна.

Ахмад ажилтнуудын бүртгэл, судалгааг шинэчилж, Билгийн тооллын XVII жарны “Буян үйлдэгч” хэмээх усан бар жилийн хаврын тэргүүн сарын шинийн нэгний баярын өдрийг тохиолдуулан Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны ахмад ажилтнуудад хүндэтгэл үзүүлж, 46 ахмад настан бүрд 30000 төгрөгөөр тооцож, нийт 1.380.000 буцалтгүй тусламж олгох тушаалын төслийг танилцуулж, батлуулан ахмад ажилтнуудын дансанд байршуулж, мессэжээр мэндчилгээ дэвшүүлсэн.

Мөн Ахмадын өдрийг тохиолдуулан Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны ахмад ажилтнуудад хүндэтгэл үзүүлж, 49 ахмад настан бүрт 54000 төгрөгөөр тооцож олгох, нийт 2.646.000 төгрөгийн буцалтгүй тусламж олгох тушаалын төслийг танилцуулж, батлуулан ахмад ажилтнуудын дансанд байршуулж, мессэжээр мэндчилгээ дэвшүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын болон албаны даргын тушаал, шийдвэрийг үндэслэн шинээр томилогдсон болон дэвшин томилогдсон нийт 39, 2022 онд цалингийн шатлал, төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдэл шинэчлэгдсэн 25 алба хаагч, Засгийн газрын 2022 оны “Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 192 дугаар тогтоолын дагуу цалингийн зэрэглэлийг шинэчлэн тогтоосон Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалд ажиллаж буй үйлчилгээний 4 ажилтан, ЦЕГ-ын даргын тушаалаар нэмэгдэл олгосон 1, МДШШУА-ны даргын тушаалаар нууцын нэмэгдэл олгосон 1, мэргэжлийн зэргийн нэмэгдэл олгосон 20, Төрийн дээд одон, медаль, Хууль зүй, дотоод хэргийн яам, ЦЕГ-ын шагналаар шагнагдсан 35, цол олгогдсон 14, хөдөлмөрийн гэрээ цуцалсан 4, хөдөлмөрийн гэрээ байгуулсан 3, сахилгын арга хэмжээ авагдсан 2, нийт 148 алба хаагчийн цахим сангийн баяжилтийг хийж, ахлагч бүрэлдэхүүний хувийн хэргийг журамд заасан дарааллын дагуу хавтаслаж, гялгар хавтаст хийж, сейфэнд хадгалж, тэдэнтэй холбоотой өргөдөл, хүсэлт, байгууллагын тушаал, шийдвэрийн хуулбарыг хувийн хэрэгт хийн баяжуулав.

Мөн Төрийн албаны зөвлөлийн “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим <https://hrm.csc.gov.mn/> системд байгууллагын бүтэц, албан тушаалыг үүсгэж, алба хаагчдын ерөнхий мэдээлэл, ажлын түүх, цалин, нэмэгдлийн талаар оруулж, хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн, цалингийн өөрчлөлт зэрэг хөдөлгөөнийг тухай бүр хийж, цахим системийг баяжуулж үйл ажиллагаандаа ашиглаж хэвшсэн.

Хоёр. Хүний нөөцийн сул орон тоог нөхөх, нөөц бүрдүүлэх чиглэлээр:

Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргын 2022.09.12-ны өдрийн 3/314 дугаартай албан бичгээр ирүүлсэн ажлын чиглэлийн дагуу тус албаны ахлагч бүрэлдэхүүнээс энэ оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээг харгалзан “Офицер албан тушаалд шатлан дэвшүүлэх нөөц”-д бүртгүүлэхээр 3 алба хаагчийн саналыг хүргүүлж, Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2022.10.12-ны өдрийн Б/15 дугаар тогтоолоор нөөцөд бүртгэгдэж, албан тушаалд томилогдсон.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын сул орон тоог нөхөх, нөөц бүрдүүлэх зорилгоор сонгон шалгаруулах элсэлтийн шалгалтыг зохион байгуулахтай холбогдуулан ЦЕГ-ын дэд даргын 2021 оны 3/447, 2022 оны 3/128, 3/257, 3/351 дугаартай “Мэдээлэл хүргүүлж, бүртгэлийн ажил эхлүүлэх тухай” албан бичгээр өгсөн ажлын чиглэлийн дагуу албаны хэмжээнд төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнээс сонгон шалгаруулах элсэлтийн шалгалтыг энэ оны 1,4,7,11 дүгээр сард тус тус зохион байгуулсан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын “Мэргэжил олгох сургалтын элсэлтийн шалгалтыг зохион байгуулах, ажлын хэсгийн бүрэлдэхүүн, хуваарь, төлөвлөгөөг батлах тухай” тушаалаар байгуулагдсан дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллах алба хаагчаас Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл” мэдүүлгийн хуудсыг бөглүүлсэн.

Сонгон шалгаруулалтаар тус албанаас Мэдээллийн технологи, программ хангамж, сүлжээний дэд бүтцийн бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй, 35 хүртэлх насны иргэдийг “Программ хангамж хариуцсан инженер”, “Систем хариуцсан инженер”, “Мэдээллийн аюулгүй байдал хариуцсан инженер”, эмч эмнэлгийн мэргэжилтэй “Мэдээлэл хүлээн авагч /103/-ийн “офицер”, бүрэн дунд боловсролтой, хугацаат цэргийн албыг биеэр болон дүйцүүлэн хаасан, жолооны “BC” ангилалтай, 30 хүртэлх насны иргэдийг “Хөдөлгөөнт холбооны техникч”-ийн “ахлагч” албан тушаалд тус тус сонгон шалгаруулах талаар зар мэдээллийг “Мэдээлэл, дүн шижилгээ, шуурхай удирдлагын алба”-ны пэйж хуудас болон <https://information.police.gov.mn/>, Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн [eincenter.police.gov.mn](http://eincenter.police.gov.mn) цахим сайтууд тус тус байршуулсан.

Элсэлтийн шалгалтад хамрагдах хүсэлт гаргасан 13 иргэн, тусгай мэдлэг шаардсан боловсрол, мэргэжлийн шаардлагыг хангасан ч ажилласан жилийн шаардлага хангахгүйгээс “Офицер албан тушаалд шатлан дэвшүүлэх нөөц”-д бүртгэгдээгүй 2 алба хаагчийг тус тус бүртгэж, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/179 дүгээр тушаалаар баталсан “Цагдаагийн байгууллагад ажиллах иргэнд тавигдах тусгай шаардлага, шалгуур үзүүлэлт тогтоох журам”-ын дагуу судалж, бүртгэлийг Хүний нөөцийн хэлтэст хүргүүлсэн.

Судлагдсан иргэд болон алба хаагчдад цахим шалгалтын талаарх мэдээллийг хүргэж, шалгалт, сургалтын зааварчилга бүхий гарын авлагыг өгч, бүртгэлийн дугаарыг олгож, хувийн бэлтгэлээ хангаж ирэх талаар тайлбарлаж өгсөн.

Шалгалт зохион байгуулах батлагдсан хуваарийн дагуу тусгай бэлтгэл, бие бялдрын шалгалтуудыг Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн фитнес танхим /100м, 3000м гүйлтийг 5 дугаар сургуулийн хөл бөмбөгийн талбай, Дүнжингаравын дугуйн зам дээр/-д зохион байгуулахаар бэлтгэж, цар тахлын халдвар хамгааллын дэглэмийг баримтлан ариутгал, халдваргүйжүүлэлт хийж, шалгалтад хамрагдах иргэдийн коронавируст халдвар (Ковид-19)-ын PCR шинжилгээний хариу болон вакцинд хамрагдсан талаарх гэрчилгээг үндэслэн биеийн халууныг үзэж, амны хаалт зүүлгэж, гарыг ариутган шалгалтын өрөөнд нэвтрүүлж, эрүүл мэндийн асуумжийг хүн тус бүрээр бөглүүлж, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/179 дүгээр тушаалаар баталсан “Цагдаагийн байгууллагад ажиллах иргэнд тавигдах тусгай шаардлага, шалгуур үзүүлэлт тогтоох журам”-ын 3.2-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу шалгалтыг авч, үнэлгээг нэгтгэн Хүний нөөцийн хэлтэст хүргүүлсэн.

Цахим шалгалтуудыг тус албаны байрлаж буй Цагдаагийн ерөнхий газрын III дугаар байр болон Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн байранд зохион байгуулахаар бэлтгэж, ширээ, сандал, компьютерыг байрлуулж, цар тахлын халдвар хамгааллын дэглэмийг

баримтлан ариутгал, халдваргүйжүүлэлт хийж, шалгалтад хамрагдах иргэдийн коронавируст халдвар (Ковид-19)-т PCR шинжилгээний хариу болон вакцинд хамрагдсан талаарх гэрчилгээг үндэслэн иргэний үнэмлэх, бүртгэлийн лавлагаанд тулгалт хийж, биеийн халууныг үзэж, амны хаалт зүүлгэж, гарыг ариутган нэвтрүүлж, эрүүл мэндийн асуумжийг хүн тус бүрээр бөглүүлж, “Ерөнхий мэдлэг”, “Монгол хэлний ярианы болон бичгийн чадвар”, “Сэтгэл зүйн”, Эссэ бичлэгээр тус тус авч, элсэлтийн шалгалтуудыг зохион байгуулж, биелэлтийг Хүний нөөцийн хэлтэст тухай бүр хүргүүлэн ажилласан.

Сонгон шалгаруулалтад 11 иргэн тэнцэж, нөөцөд бүртгэгдэж, 1 иргэн Мэдээллийн технологи, холбооны төвийн Мэдээллийн технологийн хэлтсийн програм хангамж хариуцсан инженерээр, 2 иргэн Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн Шуурхай удирдлагын хэлтэс /103/-т мэдээлэл хүлээн авагчаар, 1 иргэн мөн төвийн Техник ашиглалтын хэлтсийн програм хангамж хариуцсан инженерээр, 3 иргэн өөрийн хүсэлтээр нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад ажиллахаар хүсэлт гаргаж тус тус томилогдсон, 3 иргэн эмч эмнэлгийн албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилогдохоор нөөцөд бүртгэлтэй, 1 иргэн хувийн байгууллагад ажиллаж байна.

Мөн тусгай мэдлэг шаардсан боловсрол, мэргэжлийн шаардлагыг хангасан ч ажилласан жилийн шаардлага хангахгүйгээс “Офицер албан тушаалд шатлан дэвшүүлэх нөөц”-д бүртгэгдээгүй 2 алба хаагчийг сонгон шалгаруулалтад хамруулж, нөөцөд бүртгүүлж, МТХТ-ийн Холбооны хэлтэс болон Мэдээллийн технологийн хэлтэст тус тус томилуулсан.

*Гурав. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Алба хаагчдын ажлыг үнэлэх /код-111/ журам”-ын хэрэгжилтийг хангах чиглэлээр:*

Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын дагуу мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах жагсаалтад бүртгүүлэхээр албаны харьяа нэгжүүдээс ирүүлсэн 114 алба хаагчийн санал, баримт бичгийг нэгтгэн албаны даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, 2021 оны жилийн эцсийн ажлын үр дүнгээр “А буюу маш сайн” үнэлэгдсэн, болзол, шалгуур хангасан нийт 107 алба хаагчийн санал, холбогдох бусад баримт бичгийг Хүний нөөцийн хэлтэст хүргүүлж, Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн тогтоолоор “Албан тушаал дэвшүүлэх” нөөцөд бүртгэгдэж, <http://system.police.gov/>-ийн “Гарын авлага”-“Хүний нөөц” зэсэнд байршуулсан.

Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын дагуу алба хаагчийн ажлын төлөвлөгөөний биелэлтийн 2022 оны 1 дүгээр улирлын явцын ярилцлагыг хийж, ирүүлэх талаарх 2022.03.22-нд 8а/544 дугаартай албан бичгийг зохион байгуулалтын нэгжүүдэд хүргүүлж, ирүүлсэн саналын дагуу 2022 оны 1 дүгээр улирлын ажлын үр дүнгээр 51 алба хаагчид албаны даргын тушаалаар мөнгөн урамшуулал олгов.

Мөн журмын дагуу алба хаагчдын 2022 оны эхний хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний багийг албаны даргын тушаалаар байгуулж, нарийн бичгийн даргаар ажиллан, алба хаагчдын төлөвлөгөөний эхний хагас жилийн тайланг баталгаажуулж, 06 дугаар сарын 17-ны дотор үнэлгээний багт ирүүлэх талаар 2022.06.07-ны өдрийн 8а/1181 дугаартай албан бичгийг зохион байгуулалтын нэгжүүдэд хүргүүлж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2022 оны 100 дугаар тушаалаар батлагдсан “Ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний хуудасны загвар”-ын дагуу тус албаны 4 хэлтэс, 2 төвийн үүрэг гүйцэтгэж байгаа 242 алба хаагчаас үнэлбэл зохих 226 алба хаагчийн 210 буюу 92.9 хувь нь үнэлж, /сургалтын чөлөөтэй 2, томилогдоод 6 сар болоогүй 9, нийт 11 алба хаагч болон 5 нэгжийн дарга үнэлэгдээгүй/ баталгаажуулан, “Үнэлгээний хуудас”-ыг алба хаагчдын хувийн хэрэгт нэгтгүүллээ. Хоёрдугаар улирлын ажлын үр дүнгээр А,В үнэлэгдсэн алба хаагчдад мөнгөн урамшуулал олгох саналыг удирдлагад танилцуулж, албаны даргын тушаалаар 59 алба хаагчийг урамшуулсан.

Мөн журмын дагуу алба хаагчийн ажлын төлөвлөгөөний биелэлтийн 2022 оны 3 дугаар улирлын явцын ярилцлагыг хийж, ирүүлэх талаарх 2022.09.21-ний 13а/1802 дугаартай албан бичгийг зохион байгуулалтын нэгжүүдэд хүргүүлж, ирүүлсэн саналын дагуу 2022 оны 3 дугаар улирлын ажлын үр дүнгээр 52 алба хаагчид мөнгөн урамшуулал олгов.

Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын дагуу тус албаны 4 хэлтэс, 2 төвийн алба хаагчдын 2022 оны ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх үнэлгээний багийг байгуулж, нарийн бичгийн даргаар ажиллан, журмын дагуу үнэлж, холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт, албаны дотоод журмыг баримтлан алба хаагчдыг шатлан дэвшүүлэх нөөцөд бүртгүүлэх саналыг Хүний нөөцийн хэлтэст хүргүүлж, албаны даргын тушаалаар ажлын үр дүнгээр 75 алба хаагчид мөнгөн урамшуулал олгов.

**Дөрөв. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Шагнал урамшил олгох /код 925/” журмын хэрэгжилтийн талаар:**

Ардын хувьсгалын болон Цагдаагийн байгууллагын 101, Бүгд Найрамдах Улс тунхагласны 98 жилийн ойг тохиолдуулан Төрийн одон, медаль, Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газрын шагналаар шагнуулах алба хаагчдын материалыг ирүүлэх чиглэлийг 2022.03.25-ны өдрийн 8а/588, 2022.09.01-ны өдрийн 13/1634 дугаартай албан бичгээр нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад хүргүүлж, албаны харьяа нэгжүүдээс шагнал олгуулах 231, хугацааны цол олгуулах 109 алба хаагчийн нэрийг дэвшүүлж ирүүлснийг удирдлагад танилцуулж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар баталсан “Монгол Улсын цол хүртээх, одон медалиар шагнах тухай журам”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны А/55 дугаар тушаалаар батлагдсан “Хууль зүй, дотоод хэргийн салбарын шагнал олгох журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/99 дүгээр тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын шагналын төрөл батлах тухай” журам, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан “Шагнал, урамшил олгох журам /код-925/-д заасан тус тус болзол, шаардлага хангасан 3 алба хаагчийг Төрийн дээд шагнал “Цэргийн гавьяаны улаан тугийн одон”-оор, 4 алба хаагчийг “Цэргийн гавьяаны одон”-оор, 2 алба хаагчийг “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар, 20 алба хаагчийг “Цэргийн хүндэт медаль”-аар, 1 алба хаагчийг Хууль зүй, дотоод хэргийн яамны “Хууль зүйн албаны тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр, 9 алба хаагчийг Хууль зүй, дотоод хэргийн яамны “Цагдаагийн алдар” хүндэт тэмдгээр, 9 алба хаагчийг “Хүндэт жуух бичиг”-ээр, 65 алба хаагчийг Цагдаагийн ерөнхий газрын шагнал “Цагдаагийн гавьяа” тэмдгээр, 66 алба хаагчийг “Хүндэт жуух”-аар, 2 алба хаагчийг “Спортын алдар” тэмдгээр, 39 алба хаагчийг “Албаны төлөө-I,II,III” тэмдгээр нийт 224 алба хаагчийг шагнуулахаар нэр дэвшүүлж, Цагдаагийн албаны тухай хууль болон Засгийн газрын 2017 оны 72 дугаар тогтоолоор баталсан “Цагдаагийн бага, дунд, ахлах цол олгох, бууруулах, хураан авах, сэргээх журам”-д заасан болзол, шаардлага хангасан 1 алба хаагчид хугацааны “цагдаагийн хурандаа”, 7 алба хаагчид хугацааны “цагдаагийн дэд хурандаа”, 14 алба хаагчид хугацааны “цагдаагийн хошууч”, 16 алба хаагчид хугацааны “цагдаагийн ахмад”, 29 алба хаагчид хугацааны “цагдаагийн ахлах дэслэгч”, 28 алба хаагчийг офицерын бүрэлдэхүүнд оруулж, “цагдаагийн дэслэгч” цол олгуулах, 1 алба хаагчийн “цагдаагийн ахлах дэслэгч” цолыг сэргээлгэх саналыг, 2 алба хаагчид хугацааны “цагдаагийн ахлах ахлагч”, 5 алба хаагчид хугацааны “цагдаагийн ахлагч” цол олгох зөвшөөрөл авахаар холбогдох баримт бичгийг Хүний нөөцийн хэлтэст хүргүүлсэн. Мөн тус албанаас цагдаагийн байгууллагад 20 /хорь/ болон түүнээс дээш жил ажилласан “цагдаагийн гавьяа” тэмдгээр шагнагдаагүй алба хаагчийн судалгааг гаргаж, ХНХ-т хүргүүлэв.

Үүнээс албаны зохион байгуулалтын нэгжээс Төрийн дээд одон, медалиар 6, Хууль зүй, дотоод хэргийн яамны шагналаар 5, ЦЕГ-ын шагналаар 55 алба хаагч тус тус шагнагдаж, 54 алба хаагч цол олгогдож, ЦЕГ-ын даргын тушаалаар үндсэн цалингийн 40 хувиар 1, 20 хувиар 3 алба хаагчийг тус тус урамшуулсан.

Алба хаагчдад цол, шагнал гардуулах арга хэмжээг зохион байгуулж, албаны <http://information.police.gov.mn/> вебсайт болон пэйж хуудсаар сурталчлав.

Мөн Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын хэмжээнд “Алба хаагчдаас гаргаж буй сахилга, ёс зүйн зөрчлийн хэлбэрээр богино хэмжээний видео шторк бэлтгэх”-д идэвх зүтгэл гарган ажилласан 1 алба хаагч ЦЕГ-ын даргын, 5 алба хаагч МДШШУА-ны даргын тушаалаар, 2021 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн үйл ажиллагааны дүнгээр 2 алба хаагч ЦЕГ-ын даргын, 1 алба хаагч МДШШУА-ны даргын тушаалаар албан тушаалын үндсэн цалингийн тодорхой хувиар нэмж, урамшуулсан.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын удирдах ажилтны 2022 оны сургалт, зөвлөгөөн зохион байгуулахад идэвх санаачилгатай ажилласан 5, Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчдын дунд зохион байгуулагдсан “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйл, шалтгаан нөхцөл, түүнийг арилгахад анхаарах асуудал” сэдэвт илтгэлийн уралдаанд тусгай байр эзэлсэн, Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргын 2022 оны А/16 дугаартай тушаалаар байгуулагдсан “Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын 2013 оноос өмнөх цаасан мэдүүлэг, 2013 оноос хойш баталгааны маягт, нэгжүүдийн тайланг бүртгэлжүүлэх” үүрэг бүхий ажлын хэсэгт богино хугацаанд үр бүтээлтэй ажилласан, Монгол Улсад орчин цагийн цагдаагийн байгууллага, дотоодын цэрэг үүсэж хөгжсөний 100 жилийн ой, цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагуудын 2022 оны “Дартс”-ын аварга шалгаруулах тэмцээнээс “Мөнгөн” медаль хүртсэн, “Чөлөөт бөх”-ийн аварга шалгаруулах тэмцээнээс “Алтан медаль” хүртсэн тус тус нэг алба хаагчийн үндсэн цалинг нэмж, урамшуулсан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/310 дугаар тушаалаар шинэчлэн баталсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Тэргүүний алба хаагч, байгууллага шалгаруулах /код 133/ журам” шинэчлэн батлагдсантай холбогдуулан МДШШУА-ны даргын 2022 оны А/23 дугаар тушаалаар “Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны хөдөлмөрийн болон ажил, мэргэжлийн аварга алба хаагч шалгаруулах журам”-ыг шинэчлэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, нарийн бичгийн даргаар ажиллаж, 2022 оны А/25 дугаар тушаалаар “Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны ажил, мэргэжлийн аварга алба хаагч шалгаруулах журам”-ыг батлуулав.

Журам батлагдсантай холбогдуулан МДШШУА-ны даргын 2022 оны А/24 дүгээр тушаалаар “Цагдаагийн төв байгууллагын 2022 оны “Хөдөлмөрийн аварга”, “Оны онцлох алба хаагч”-ийн төрөлд нэр дэвшүүлэх, Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны 2022 оны “Ажил, мэргэжлийн аварга” алба хаагчийг тус тус шалгаруулах” үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, нарийн бичгийн даргаар ажиллаж, шалгуур хангасан алба хаагчдын нэрийг дэвшүүлж, материалыг ирүүлэх чиглэлийг алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга нарт 2022.11.30-ны 13/2454 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

Алба нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас Цагдаагийн төв байгууллагын 2022 оны хөдөлмөрийн аварга болон Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны ажил мэргэжлийн аварга алба хаагч, тэргүүний нэгж, хамт олонд нэр дэвшүүлж ирүүлсэн алба хаагчдын материалыг нэгтгэн ажлын хэсгийг хуралдуулж, хэлэлцүүлэн, удирдлагад танилцуулж, Цагдаагийн төв байгууллагын 2022 оны хөдөлмөрийн аваргаар шалгарсан алба хаагчдын баримт бичгийг бүрдүүлж, ЦЕГ-ын ажлын хэсэгт хүргүүлж, Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны ажил мэргэжлийн аварга алба хаагч, тэргүүний нэгж, хамт олноор шалгарсан алба хаагчдыг шагнаж урамшуулах тушаалын төслийг танилцуулж, батлуулж, шагнал гардуулах арга хэмжээг зохион байгуулав.

**Тав. Алба хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, эрх ашгийг хамгаалах ажлын хүрээнд:**

- Цагдаагийн ерөнхий газрын удирдлагыг төлөөлөн Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын холбогдох албан тушаалтантай мэдээлэл солилцон хамтран ажиллаж, төв, орон нутгийн олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн талаарх мэдээллийг нэгтгэн хянаж, цагдаагийн байгууллагын дарга нартай шууд

холбогдож, мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган үүрэг, чиглэл өгч, биелэлт үр дүнг тооцон ажиллаж буй тус албаны ОНБШУЗХ-ийн ерөнхий зохицуулагчид болон цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд зохион байгуулсан нууцын зэрэглэл бүхий ажлын мэдээг улсын хэмжээнд нэгтгэх /ЦБҮАЖ-ын код 200.06.07-д/ өндөр хариуцлагатай үүргийг гүйцэтгэж буй мөн хэлтсийн мэдээлэл хүлээн авагч-жижүүрийн цагдаа нарын эрх зүйн байдлыг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлагын хүрээнд “Ерөнхий зохицуулагч” албан тушаалын 4 орон тооны цолны зэрэглэлийг “цагдаагийн хурандаа”, “Мэдээлэл хүлээн авагч-жижүүрийн цагдаа” албан тушаалын 4 орон тоог “Мэдээлэл хүлээн авагч-офицер” албан тушаал болгон өөрчилж, цалингийн зэрэглэлийг ТТ-9, цолны зэрэглэлийг “цагдаагийн ахмад” болгох тухай санал;

- Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын холбоо, мэдээлэл, технологийн инженер, техникийн ажилтнуудын нийгмийн баталгааг хангах, тэдний тогтвор сууршил, үр бүтээлтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлж, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, үйл ажиллагааны чанар, хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын холбоо, мэдээллийн инженерийн орон тоог шат дараатайгаар нэмэгдүүлэх тухай болон холбоо, мэдээллийн инженерийн албан тушаалын нөөцөд бүртгэгдсэн иргэдийн тухай тус тус танилцуулгыг ЦЕГ-ын даргад хүргүүлсэн.

- Цагдаагийн байгууллагын бие бүрэлдэхүүн болон тэдэнд ашиглагдаж буй радио станцын тоо өссөөр байгаа нь тус албаны радио холбоо хариуцсан 2 ахлах инженерийн ажлын ачаалал нэмэгдэж, өдөр тутмын хэвийн ажиллагаа алдагдах, эмх замбараагүй байдлын үед радио холбооны сүлжээ доголдох эрсдэлтэй байх тул Мэдээллийн технологи, холбооны төвийн Холбооны хэлтсийн “Тусгай шуудангийн мэргэжилтэн” орон тоог “Радио холбооны инженер”, “Жолооч” /ТҮ-3/ орон тоог “Радио холбооны техникч” /ТТ-8/ болгон өөрчлөх;

- Тус албаны хэмжээнд бичээч, архивчийн ажлыг “Бичиг хэргийн эрхлэгч-даргын туслах” нь давхар гүйцэтгэснээс ажлын ачаалал нэмэгдэж, тус орон тоонд алба байгуулагдсанаас /2018 оноос/ хойш 6 алба хаагч шилжин томилогдож, тогтвор суурьшилгүй ажиллаж, архивын хадгалалт, хамгаалалт, нөхөн бүрдүүлэлт, ашиглалтын ажил хангалтгүй хийгдсээр байгаа ба алба байгуулагдсан 2018 оноос хойших баримтыг ангилан архивын хадгаламжийн нэгж бүрдүүлж, архивын баримтыг тоон болон цахим хэлбэрт шилжүүлэх, хадгалах хугацаа дууссан баримтыг нягтлан шалгах ажлын комиссоор хэлэлцүүлэх, Цагдаагийн ерөнхий газрын төв архивд шилжүүлэх, 4 жил тутам зохион байгуулагддаг архивын улсын үзлэгт бэлтгэх зэрэг архивын хадгалалт, хамгаалалт, нөхөн бүрдүүлэлт, ашиглалтын ажлыг тогтмол хэрэгжүүлэх “архивч” орон тоог шинээр бий болгож, алба хаагчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх хэрэгцээ шаардлагын хүрээнд тус албаны Мэдээллийн технологи, холбооны төвийн “Бичиг хэргийн эрхлэгч, бичээч, архивч” албан тушаалын орон тоог Захиргааны удирдлагын хэлтсийн “Бичээч-архивч” орон тоо болгон өөрчлөх;

- Тус албаны 4 нэгжийн 67 алба хаагч Цагдаагийн ерөнхий газрын III байранд байрлаж үүрэг гүйцэтгэж байгаа ба энэхүү барилга нь 1933 онд баригдаж, 89 жил ашиглагдсан, барилгын ерөнхий цахилгаан, сантехникийн тоног, төхөөрөмж муудсаны улмаас 2021 онд урсгал засвар хийж шинэчилсэн хэдий ч байнгын засвар, үйлчилгээ, арчилгаа хийгдэхгүйгээс эвдрэл, гэмтэл гарч, байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах, цахилгаан сантехникийн тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хариуцан ажиллах, засвар, үйлчилгээ хариуцсан орон тоог шинээр бий болгох хэрэгцээ шаардлага үүссэн.

- Мөн Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2001 оны 03 дугаар тушаалаар баталсан “Нэг үйлчлэгчийн цэвэрлэх талбай, ажлын үлгэрчилсэн хэмжээ”-нд нэг үйлчлэгчид ногдох талбайн хэмжээ 300-350м.кв гэж заасан ба тус албаны байрны 1445м.кв талбай бүхий 1,2,4 давхрын өрөө, тасалгаануудын цэвэрлэгээ, үйлчилгээг 2 үйлчлэгч хийж байгаа нь илүү цагаар ажиллах, ээлжийн амралт эдлэх, эрүүл мэндийн шалтгаанаар чөлөөлөгдөх үед ажлын ачаалал нэмэгдэж, байгууллагын дотоод, гадаад өнгө, үзэмж, цэвэрлэгээ, үйлчилгээний хэвийн байдал алдагдаж байгаа тул тус албаны Захиргааны удирдлагын хэлтсийн “Диспетчер-харуул” албан тушаалын 4 орон тоог “Үйлчлэгч”, “Мужаан”, “Цахилгаанчин”, “Сантехникийн засварчин” мөн “Цахилгаанчин-слесарь” орон тоог

“Сантехникийн засварчин” орон тоо болгон өөрчлөх саналыг тус тус Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газарт хүргүүлсэн.

- Алба хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, шаардлагатай техник хэрэгсэл, эд зүйлээр хангах судалгаа, шинжилгээ хийж, удирдлагад танилцуулах, шийдвэрлүүлэх, байгууллагын өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдал, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, үйлчилгээний ажилтан нарын өдөр тутмын үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллах “Аж ахуйн ажил хариуцсан алба хаагч”-ийг өөрийн бүтэц, орон тоо, цалингийн зардалд багтаан шийдвэрлүүлэх саналыг Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газарт хүргүүлж, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/229 дугаар тушаалаар тус албаны Мэдээллийн технологи, холбооны төвийн Холбооны хэлтсийн “Авто, аж ахуй ашиглалт хариуцсан инженер” орон тоог Захиргааны удирдлагын хэлтсийн “Авто ашиглалт, аж ахуйн хариуцсан ажилтан” болгон шийдвэрлэж, албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 02, 03 дугаар тогтоолд нийцүүлэн, батлагдсан загварын дагуу боловсруулж ХНХ-т хүргүүлсэн.

Мөн ЦЕГ-ын даргын 2021 оны А/314 тушаалаар тус албаны Мэдээллийн технологи, холбооны төвийн Мэдээллийн технологийн хэлтсийн бүтцэд “Систем хөгжүүлэлтийн тасаг” шинээр байгуулагдсан, мөн Кибер аюулгүй байдлын тухай хууль шинээр батлагдсантай холбогдуулан Мэдээллийн технологийн хэлтэс, Цахим мэдээллийн аюулгүй байдлын хэлтэс, Холбооны хэлтсийн албан тушаалын тодорхойлолтыг “Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 02, 03 дугаар тогтоолд нийцүүлэн, батлагдсан загварын дагуу боловсруулж, Хүний нөөцийн хэлтэст 2022.05.05-ны өдрийн 8г/8268 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 23.5-д “Тухайн байгууллагын чиг үүрэгт хууль тогтоомжоор өөрчлөлт орсноос бусад тохиолдолд энэ хуулийн 23.3-т заасан тусгай шаардлага болон албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулахыг хориглоно” гэж заасан бөгөөд Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Төрийн албаны тухай хуульд 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр орсон нэмэлт өөрчлөлт, “Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хууль, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 05 дугаар сарын 03-ны А/160 дугаар тушаал “Мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индекс шинэчлэн батлах тухай”, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/199 дүгээр тушаалаар “Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичиг” зэрэг хууль, тогтоомж шинэчлэн батлагдсантай холбоотойгоор тус албаны нийт албан тушаалын тодорхойлолтуудыг дахин боловсруулж, ХНХ-т хүргүүлээд байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/256 дугаар тушаалаар Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдын дээд боловсролын зэргийн диплом “Дээд боловсролын удирдлага, мэдээллийн систем”-д бүртгэлтэй эсэхийг шалгах ажлын хэсэг байгуулагдсантай холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын дэд даргын 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 3/338 дугаартай албан бичгээр өгсөн ажлын чиглэлийн дагуу Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны даргын 2022 оны А/16 дугаар тушаалаар Дэд ажлын хэсгийг байгуулж, тус ажлыг шуурхай, үр дүнтэй, нууцлалыг ханган зохион байгуулж, албаны хэмжээнд дээд боловсролын зэрэгтэй нийт 180 алба хаагчийн дипломыг шалган хуулбарлаж, “e-mongolia” болон Хур системээс гарах боломжтой лавлагааг PDF файлаар болон 610 хуудас бүхий цаасаар, өгөгдсөн загвар хүснэгтийн дагуу судалгааг excel файлаар тус тус ХНХ-т хүргүүлэв.

МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ, ШУУРХАЙ УДИРДЛАГЫН АЛБА